БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 30 өдөр Дугаар А/808 Булган сум

Барилгын засварын ажил ашиглалтад оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 49 дүгээр зүйлийн 49.1, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4, 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Гурванбулаг сумын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлын зураг төсөл, норм дүрэм, стандартын шаардлагад нийцэж байгаа нь барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 47/2022 дугаартай дүгнэлтээр баталгаажсан тул ахуйн үйлчилгээний зориулалтаар 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс ашиглалтад оруулсугай.

2.Барилга байгууламжийн эзэмшигч, ашиглагч нь тухайн барилга байгууламжийн үндсэн хөрөнгийг бүртгэлийн байгууллагад ажлын 10 хүртэл хоногт багтаан бүртгүүлж, барилга ашиглалтын дүрмийг чанд мөрдөж, барилгын хувийн хэрэг хөтлөх, барилгад дур мэдэн өөрчлөлт хийх зэрэг ашиглалтын горимыг зөрчихгүй ашиглахыг барилгын ашиглагч, эзэмшигч Гурванбулаг сумын ЗДТГ –ын дарга (Б.Эрдэнэтуяа)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү барилгын туршилт тохируулгын хугацааг Монгол Улсын барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1–ийн дагуу 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл, тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6–н дагуу 2026 оны 11 дүгээр сарын 25–ны өдөр хүртэл энэ хугацаанд гүйцэтгэгчээс шалтгаалсан эвдрэл, гэмтлийг гүйцэтгэгч "Бэсүб констракшн" ХХК -ийн хөрөнгөөр засуулах ажлыг барилгын ашиглагч, эзэмшигч Гурванбулаг сумын ЗДТГ–ын дарга (Б.Эрдэнэтуяа)-д үүрэг болгосугай.

4.Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийг үндэслэж, ажлын долоон өдрийн дотор ашиглалтын гэрчилгээ олгож, барилга ашиглалтын явцад тогтмол хяналт тавьж ажиллахыг мэргэжлийн хяналтын газар (Б.Батболд)-т үүрэг болгосугай.

5.Ашиглалтад оруулсан барилга байгууламжийн баримт материалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эх хувиар нь хүлээн авч архивын нэгж үүсгэн хадгалахыг төрийн архивын тасаг (Д.Батсайхан)-д үүрэг болгосугай.

6.Барилгын ашиглалтын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, тайлагнан ажиллах, барилгын засварын ажлыг барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын дүгнэлт, Монгол Улсын барилгын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.2–н дагуу ашиглалтын гэрчилгээг авахыг Гурванбулаг сумын ЗДТГ –ын дарга (Б.Эрдэнэтуяа) -д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

6322011111